



ДУНДГОВЬ АЙМАГ
ДЭЛГЭРЦОГТ СУМЫН ЗАСАГ ДАРГЫН
ЗАХИРАМЖ

2023 оны 05 сарын 17 өдөр

Дугаар 1/58

Амардалай

Ажлын хэсэг байгуулах тухай

Монгол Улсын Засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хуулийн 59 дүгээр зүйлийн 59.1.11, 66 дугаар зүйлийн 66.1 дахь заалт, Мал амьтны эрүүл мэндийн тухай хуулийн 34 дүгээр зүйлийн 34.3.3 дахь заалтыг тус тус үндэслэн ЗАХИРАМЖЛАХ нь:

1.Сумын Орон нутгийн хөгжлийн сангийн 14.600.000 (Арван дөрвөн сая зургаан зуун мянган) төгрөгийн хөрөнгө оруулалтаар нийлүүлэгдэх "Халдварт өвчнөөс урьдчилан сэргийлэх Мал эрүүлжүүлэх дархлаажуулахад зориулагдсан вакцин хадгалах хөргүүр"-ийн тоног төхөөрөмж нийлүүлэх ажлыг хүлээн авах ажлын хэсгийг дараах бүрэлдэхүүнтэй байгуулсугай.

Ажлын хэсгийн ахлагч: Л.Золжаргал (Засаг даргын орлогч)

Нарийн бичгийн дарга: Д.Наранцэцэг (МЭТ-ийн дарга)

Гишүүд: Б.Баттогтох (ХАА хариуцсан мэргэжилтэн)

Н.Даваацэрэн (Малын эмч)

Б.Баярмаа (ЗДТГ-ын нярав)

2.Тоног төхөөрөмж нь техникийн тодорхойлолтод тусгагдсан үзүүлэлттэй эсэхэд хяналт тавьж, шаардлагад нийцсэн тоног төхөөрөмжийг хүлээн авах, холбогдох акт баримтыг журмын дагуу үйлдэж, Засаг даргын орлогчид хүргүүлэхийг ажлын хэсгийн гишүүдэд үүрэг болгосугай.

ДАРГА

М.БАЯРСҮХ

